

АГУУЛГА

ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	3
БҮЛЭГ-1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
1.1. Төслийн байршил.....	4
1.2. Орчны төлөв байдал.....	5
1.3. Ордын геологийн нөөц	6
1.4. Ордын үйлдвэрлэлийн нөөц.....	6
1.5. Уурхайн хүчин чадал, ажиллах горим	7
1.5.1. Уурхайн хүчин чадал	7
1.5.2. Уурхайн ажиллах горим	7
1.6. Уурхайн талбайд ашиглалт явуулах дараалал	8
1.7. Уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн иж бүрдэл	8
1.8. Үйлдвэрийн хүчин чадал, ажиллах горим.....	8
1.9. Үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийн иж бүрдэл	11
БҮЛЭГ-2. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮД.....	12
2.1. АГААРЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ	12
2.2. ХӨРСНИЙ ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ.....	12
2.3. УСНЫ ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ.....	12
2.4. УРГАМАЛАН НӨМРӨГТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ	13
2.5. АМЬТНЫ АЙМАГТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ	13
2.6. Төсөл хэрэгжих орчны түүх соёлын дурсгалт зүйлс	13
БҮЛЭГ-3. ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН	14
3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	14
3.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	15
3.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	16
3.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	17
3.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	17
3.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	17
3.7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	19
3.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	22
3.9. Аймаг, нийслэлийн засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ	26
3.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	27
3.11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	28
3.12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн нэгтгэл.....	29
ДҮГНЭЛТ.....	30

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбилцол	4
Хүснэгт 1.2. “Шар хөвийн хоолой” тоосгоны шаврын ордын батлагдсан геологийн нөөц	6
Хүснэгт 1.3. “Шар хөвийн хоолой” тоосгоны шаврын ордын үйлдвэрлэлийн нөөц	6
Хүснэгт 1.4. Уурхайн ажиллах горим.....	7
Хүснэгт 1.5. Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүд.....	8
Хүснэгт 1.6. Тоосго үйлдвэрлэлийн хүчин чадал төлөвлөлт	8
Хүснэгт 1.7. Тоосгоны үйлдвэрийн ажиллах горим	9
Хүснэгт 1.8. Тоосго үйлдвэрлэлийн үндсэн тоног төхөөрөмжүүд	11
Хүснэгт 3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	14
Хүснэгт 3.2. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөлт.....	16
Хүснэгт 3.3. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	19
Хүснэгт 3.4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	21
Хүснэгт 3.5. Удирдлага зохион байгуулалтын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	27
Хүснэгт 3.6. Олон нийтэд төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах хуваарь	28
Хүснэгт 3.7. 2023 оны БОМТ-ний нийт зардал, биелэлтийн үзүүлэлтүүдийн харьцуулалт	29

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1. Төслийн талбайн байршлын зураг	4
Зураг 1.2. Тоосго үйлдвэрлэлийн технологийн дамжлага схем	10
Зураг 1.3. Тоосго үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн дамжлага схем.....	11
Зураг 3.1. Уурхайн талбайд мод тарьж буй байдал	15
Зураг 3.2. Тарьсан модоо хашаажуулж хамгаалсан байдал	15
Зураг 3.3. Дүйцүүлэн хамгаалах чиглэлээр мод тарьсан ажлын тайлан	16
Зураг 3.4. Ажилчдын хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслүүд.....	17
Зураг 3.5. Аюулгүй ажиллагааны самбар	17
Зураг 3.6. Гал унтраах аюулгүй ажиллагааны хэрэгслүүд	18
Зураг 3.7. Хог хаягдлыг үйлчилгээний гэрээ	20
Зураг 3.8. Шинэ хогийн цэгийн хогийг цэвэрлэлцэв	20
Зураг 3.9. Бохир ус татан зайлуулах гэрээ.....	21
Зураг 3.10. Хөрсний шинжилгээний хариу-1	22
Зураг 3.11. Хөрсний шинжилгээний хариу-2	23
Зураг 3.12. Усны шинжилгээний хариу-1.....	24
Зураг 3.13. Усны шинжилгээний хариу-2.....	25
Зураг 3.14. Дүүрэг, хорооноосоо хамтын ажиллагааны талархал хүртэв	26

ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

№	ҮЗҮҮЛЭЛТ	УТГА
1	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	“ЭМ ЭЛ ТИ ПРЕСТИЖ” ХХК
2	Төсөл хэрэгжүүлэгчийн улсын бүртгэлийн мэдээлэл	Улсын бүртгэлийн дугаар: 9011751079 Бүртгэсэн огноо: 2006.07.25 Регистрийн дугаар: 5121442
3	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 21-хороо, 1424-12 тоот
4	Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын удирдлагын мэдээлэл	Захирал: Ц.Төмөрбаатар Утас: 9901-1583
5	Төслийн нэр	Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт орших “Шар хөвийн хоолой” нэртэй тоосгоны шаврын ордыг ил уурхайн аргаар ашиглах, тоосго үйлдвэрлэх төсөл
6	Төслийн байршил	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 32-р хороо
7	Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар	MV-014310
8	Тусгай зөвшөөрлийн хугацаа	Олгосон огноо : 2007.02.13 Дуусах огноо: 2037.02.13
9	Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ	36.4 га
10	Ордын батлагдсан геологийн нөөц	515.4 мян.м ³
11	Ордын үйлдвэрлэлийн нөөц	265.09 мян.м ³
12	Шавар олборлолтын жилийн хүчин чадал	36.43 мян.м ³
13	Тоосго үйлдвэрлэлийн жилийн хүчин чадал	10.5 сая ширхэг

БҮЛЭГ-1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


1.1. ТӨСЛИЙН БАЙРШИЛ

“Шар хөвийн хоолой” тоосгоны шаврын уурхай нь засаг захиргааны нэгжийн хувьд Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт хамаарах бөгөөд Улаанбаатар хотын төвөөс 32 км зайд байр зүйн зургийн L-48-11 тоот хавтгайд оршино.

Уг орд байрлаж буй нийт 36.4 га талбай бүхий MV-014310 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбилцолыг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 1.1. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбилцол

№	Тусгай зөвшөөрлийн дугаар	Хугацаа (жил)	Цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг
				(град, мин, сек)	(град, мин, сек)
1	MV-014310 (36.4 га)	30	1	106° 36' 38.11"	47° 52' 01.79"
2			2	106° 36' 38.11"	47° 52' 22.78"
3			3	106° 36' 11.32"	47° 52' 22.78"
4			4	106° 36' 11.32"	47° 52' 01.79"



Зураг 1.1. Төслийн талбайн байршлын зураг

1.2. Орчны төлөв байдал

Уул зүйн тогтолцоо: Уул зүйн хувьд ордын дүүрэг нь Хэнтийн уулархаг мужийн баруун урд хэсэгт хамаарагдана. Энэхүү хотгорын туйлын өндөржилт далайн түвшнээс дээш 1370-1315 м (ордын талбайн хэсэгт) байна.

Орд байрлаж буй хотгор нь баруунаас зүүн тийш чиглэлтэй, гонзгойдуу хэлбэртэй, төв хэсэгтээ хонхордуу, төв, зүүн талдаа тэгшивтэр талархаг гадаргуу үүсгэсэн байна. Уг орд нь Хойт Монголын атираат мужийн Хэнтийн синклинорийн Улаанбаатарын варисцидийн хотгорын хэмжээнд оршдог. Дээд рифей-кембрийн мандалын борог элсжингийн сери, түүний дээр үл нийцлэгээр байрлах Улаанбаатарын хотгорыг бүрдүүлэгч Хэнтийн серийн Девоны тунамал-терриген хурдас, доод-дунд карбоны элсжин-занарын, алевролит-элсжингийн 2 зузаалаг, дунд-дээд карбоны элсжин зонхилсон зузаалгууд, дөрөвдөгчийн цаг үед хуримтлагдсан эх газрын тунамал хурдсууд болон мезозойн үеийн гүний хагарал үүсэлтэй чулуулгууд тархана. Улаанбаатарын дүүргийн геологийн тогтоцыг янз бүрийн цаг хугацаанд судалгааны янз бүрийн төвшинд өмнө нь олон судлаачид судалж иржээ.

Ус зүй: Ордын талбайн гидрогеологийн нөхцлийн хувьд усан хагалбарын сүлжээний томоохон ай сав болох Туул голын хөндийн баруун салааны нэг хэсэг болох Шар хөвийн хоолойд оршдог. Туул гол нь Хойт Хэнтийн усан хагалбарын систем сайн хөгжсөн Хэнтийн нуруунаас эх авч урсан Туул голын ай савын баруун, зүүн талын олон том, жижиг голын урсацаар сэлбэгдэн урссаар Монгол орны томоохон гол болох Орхон голд цутгадаг байна.

Уур амьсгал: Цаг агаарын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай, жилийн дундаж хэм нь 25° С байна. Тус нутаг нь өвөлдөө нэлээд цас унадаг, хүйтэн, зун нь бороотой халуувтар байдаг. 1-р сард хамгийн хүйтэн /-45/ 7 сард хамгийн дулаан /+35/ жилдээ 130-400 мм зузаан тунадас унах бөгөөд дунджаар 278 мм байна. Жилийн 4 улиралд хур тунадас харилцан адилгүй унадаг бөгөөд 7, 8-р сард бороо байдлаар ихэвчлэн орно.

Дэд бүтэц: Орд орчмын талбай нь үйлдвэр уурхай, газар тариалан, модны аж ахуй сайн хөгжсөн. Талбай нь эдийн засгийн дүүрэгт орших ба томоохон суурин газруудаар хүрээлэгдэнэ. Тус дүүрэг нь зам харилцаа сайтай өвөл зуны аль ч улиралд явахад саадгүй, замын сүлжээ сайн хөгжсөн нутаг юм. Энэ бүс нутаг нь хүн амын нягтралын хувьд дунд зэрэгт орох бөгөөд хүн амын ихэнх нь газар тариалан мал аж ахуй эрхэлдэг байна.

1.3. Ордын геологийн нөөц

Геологийн тогтоцын шинж чанар, ашигт малтмалын нөөцийн хэмжээгээрээ “Шар хөвийн хоолой” тоосгоны шаврын орд нь ордын нөөцийн ангилалаар II зэргийн ордод хамаарах ба ашигт малтмалын зузаан ба чанар тогтвортой, хэмжээний хувьд дунд зэргийн ордод хамаарна.

Ордын хэмжээнд бодитой нөөц (В) тогтоогдсон ордын ашигт давхаргын дундаж зузаан нь 2.32 м, нөөц нь 345.7 мян.м³. Боломжтой нөөц (С) тогтоогдсон ордын ашигт давхаргын дундаж зузаан нь 3.72 м, нөөц нь 169.69 мян.м³ ба нийт нөөц нь (В+С) 515.4 мян.м³ байна. Хуулах хөрсний дундаж зузаан 0.2 м байна.

Хүснэгт 1.2. “Шар хөвийн хоолой” тоосгоны шаврын ордын батлагдсан геологийн нөөц

№	Нөөцийн блоккийн дугаар	Талбайн хэмжээ, м ²	Тоосгоны шаврын дундаж зузаан, м	Тоосгоны шаврын нөөц, м ³	Хучаас хөрсний зузаан, м	Хуулах хөрсний эзлэхүүн, м ³	Хуулах хөрсний шаврын харьцаа
1	В-1	36377	1.63	59149.0	0.2	7275.4	0.12
2	В-2	59025	2.48	146389.9	0.2	11805.0	0.08
3	В-3	53526	2.62	140238.1	0.2	10705.2	0.08
4	С-4	34897	2.95	102984.5	0.2	6979.4	0.07
5	С-5	22602	2.95	66698.5	0.2	4520.4	0.07
-	Нийт В	148928	2.24	345777	0.20	29785.6	0.09
-	Нийт С	57499	2.95	169683	0.20	11499.8	0.07
-	В+С	206427	2.60	515460	0.20	41285.4	0.08

1.4. Ордын үйлдвэрлэлийн нөөц

“Шар хөвийн хоолой” тоосгоны шаврын ордыг ил уурхайн аргаар ашиглах үеийн үйлдвэрлэлийн нөөц нь 265.09 мян.м³ байхаар ТЭЗҮ-д тооцож тусгасан байна.

Хүснэгт 1.3. “Шар хөвийн хоолой” тоосгоны шаврын ордын үйлдвэрлэлийн нөөц

№	Блоккийн дугаар	Хаягдал шаврын хэмжээ, мян.м ³	Хаягдлын хувь, %	Хучаас хөрсний зузаан, м	Шаврын зузаан, м	Олборлолтонд өртөх талбай, мян.м ²	Нийт хөрс хуулалт, мян.м ³	Шаврын эзлэхүүн, мян.м ³
1	В-1	1.22	3.07	0.2	1.63	24.41	6.1	38.57
2	В-2	2.46	2.02	0.2	2.48	49.2	12.3	119.56
3	В-3	2.08	1.91	0.2	2.62	41.62	10.41	106.97
	Нийт В нөөц	5.76	2.13	0.2	2.24	115.23	28.81	265.09

1.5. Уурхайн хүчин чадал, ажиллах горим

1.5.1. Уурхайн хүчин чадал

Уурхайн хүчин чадлыг техник-эдийн засгийн үндэслэлд жилд 36.43 мян.м³ тоосгоны шавар олборлон боловсруулахаар тооцож тусгасан.

1.5.2. Уурхайн ажиллах горим

“Шар хөвийн хоолой” тоосгоны шаврын уурхай нь улирлын чанартай явагдах бөгөөд 3-р сарын 1-нээс гарган бэлтгэл ажил, 4-р сарын 1-нээс 11-р сарын 1-нийг хүртэл үндсэн олборлолтын үйл ажиллагаа явагдах бөгөөд жилд нийтдээ 8 сар ажиллана.

Хүснэгт 1.4. Уурхайн ажиллах горим

№	Горимын үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Утга	Тайлбар
1	Жилийн хуанлийн хоног	хоног	365	-
2	Өвлийн улирлын сул зогсолт	хоног	141	11-р сарын 1-нээс 3-р сарын 1 хүртэл
3	Жилийн ажиллах хуанлийн хоног	хоног	224	3-р сарын 1-нээс 11-р сарын 1 хүртэл
4	Баяр ёслолын амралт	хоног	8	Хөдөлмөрийн тухай хуулийн 4.1.5, 4.1.6, 4.1.1, 4.1.10-р зүйлийн дагуу
5	Цаг агаарын саатал	хоног	5	-
6	Засвар үйлчилгээ	хоног	7	Төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус
7	Бэлтгэл ажил	хоног	24	Уурхайн бэлтгэл ажил
8	Хучаас хөрс хуулалтын ажлын хоног	хоног	205	-
9	Шавар олборлолтын ажлын хоног	хоног	180	-
10	Тоосго үйлдвэрлэх ажлын хоног	хоног	183	-
11	Хоногт ажиллах ээлжийн тоо	ээлж	1	-
12	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	10	Уртасгасан цагаар
13	Цаг ашиглалтын итгэлцүүр	-	0.85	85%
14	Нэг ээлжин дэх цэвэр ажлын цаг	цаг	8.5	Цаг ашиглалт тооцсон
15	Хоногт ажиллах бодит цаг	цаг	8.5	Цаг ашиглалт тооцсон
16	Жилд ажиллах бодит цаг	цаг	1530	Цаг ашиглалт тооцсон
17	Уурхайн цагийн хүчин чадал	м ³ /цаг	23.81	Цаг ашиглалт тооцсон
18	Уурхайн ээлжийн хүчин чадал	м ³ /ээлж	202.4	Хоногт 10 цагийн 1 ээлжээр ажиллана
19	Уурхайн хоногийн хүчин чадал	м ³ /хоног	202.4	
20	Уурхайн жилийн хүчин чадал	м ³ /жил	36430	Жилд нийтдээ 180 хоног ажиллана.

Уурхай нь хоногт 10 цагийн 1 ээлжээр ажиллах ба цаг ашиглалтын итгэлцүүр 0.85 байна гэж үзвэл хоногт нийт 8.5 цаг ажиллах юм. Жилд нийт 224 хоног ажиллах бөгөөд 180 хоногт нь цэвэр олборлолтын үйл ажиллагаа явуулна. Уурхайн хоногийн хүчин чадал 202.4 м³, цагийн хүчин чадал 23.81 м³ байна.

1.6. Уурхайн талбайд ашиглалт явуулах дараалал

“Шар хөвийн хоолой” нэртэй тоосгоны шаврын ордод ашиглалт явуулах үйл ажиллагаа нь дараах дарааллын дагуу явагддаг.

Шавар олборлолт:

ШИМТ ХӨРС ХУУЛАЛТ ► ТООСГОНЫ ШАВАР ОЛБОРЛОЛТ

Тоосго үйлдвэрлэл:

ТООСГО ҮЙЛДВЭРЛЭХ ► ХАТААХ ► ШАТААХ ► БЭЛЭН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХЭРЭГЛЭГЧДЭД НИЙЛҮҮЛЭХ.

Үүний зэрэгцээ уурхайн тээврийн замыг цэвэрлэх, хуурайшилт ихтэй үед тоосжилтыг бууруулах мөн тоног төхөөрөмжид засвар, үзлэг үйлчилгээ хийх гэх мэт туслах ажлууд хийгдэнэ.

1.7. Уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн иж бүрдэл

Уурхайд олборлолтын үйл ажиллагаа явуулахаас өмнө үржил шимт хөрсний үеийг утгуурт ачигчаар хусаж бөөгнүүлэн автосамосвалд ачиж тээвэрлэн тусгай овоолгод байршуулж стандартын дагуу хадгална.

Тухайн жилийн ашиглалтанд өртөх талбайн шимт хөрсийг хуулсаны дараа нээгдсэн шаврын үеийг экскаватораар сийрэгжүүлэн ухаж автосамосвалд ачин цааш үйлдвэрийн талбай руу тээвэрлэж тоосго үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн шавар хүлээн авах хэсэгт хүргэнэ.

Хүснэгт 1.5. Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүд

№	Техник	Марк	Тоо хэмжээ	Үзүүлэлт
1	Экскаватор	R140LC-9	1	0.6 м ³
2	Автосамосвал	Howo 272	1	8 тн
3	Утгуурт ачигч	Luigong ZL30E	1	1.5 м ³
-	Нийт	-	3	-

1.8. Үйлдвэрийн хүчин чадал, ажиллах горим

“Шар хөвийн хоолой” тоосгоны шаврын уурхайн дэргэдэх тоосгоны үйлдвэр нь жилд дунджаар 10.5 сая ширхэг тоосго үйлдвэрлэх хүчин чадалтай.

Хүснэгт 1.6. Тоосго үйлдвэрлэлийн хүчин чадал төлөвлөлт

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Жилд
1	Үйлдвэрлэх тоосгоны хэмжээ	мян.ш	10,714.29
2	Тоосгоны технологийн хаягдал, 2%	мян.ш	214.29
3	Борлуулах тоосго	мян.ш	10,500

Тоосгоны үйлдвэр нь жилд дунджаар 10.71 сая ширхэг тоосго үйлдвэрлэх ба технологийн хаягдлыг хасаж тооцсоноор 10.5 сая ширхэг тоосгыг зах зээлд нийлүүлнэ.

Тоосго үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь уурхайн үйл ажиллагаатайгаа адил улирлын чанартай явагдах бөгөөд 3-р сарын эхнээс бэлтгэл ажил, 4-р сарын эхнээс 10-р сарын сүүл хүртэл үндсэн тоосго үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явагдах бөгөөд жилд нийтдээ 7 сар ажиллах юм. Уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулах хугацаад үйлдвэрийн төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус засвар үйлчилгээний хугацаа болон хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтуудыг үндэслэн тооцоолж дараах хүснэгтэнд харууллаа.


Хүснэгт 1.7. Тоосгоны үйлдвэрийн ажиллах горим

№	Горимын үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Утга	Тайлбар
1	Баяр ёслолын амралт	хоног	7	Хөдөлмөрийн тухай хуулийн 4.1.1, 4.1.5, 4.1.10-р зүйлийн дагуу
2	Цаг агаарын саатал	хоног	10	-
3	Засвар үйлчилгээ	хоног	14	Төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус
4	Бэлтгэл ажил	хоног	30	Уурхайн бэлтгэл ажил
5	Жилд ажиллах бодит хоног	хоног	183	-
6	Хоногт ажиллах ээлжийн тоо	ээлж	1	-
7	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	10	Уртасгасан цагаар
8	Цаг ашиглалтын итгэлцүүр	-	0.85	85%
9	Жилд ажиллах бодит цаг	цаг	1555.5	Цаг ашиглалт тооцсон
10	Уурхайн цагийн хүчин чадал	мян.ш/цаг	6.9	Цаг ашиглалт тооцсон
11	Уурхайн ээлжийн хүчин чадал	мян.ш/ээлж	58.65	Хоногт 10 цагийн 1 ээлжээр ажиллана
12	Уурхайн хоногийн хүчин чадал	мян.ш/хоног	58.65	
13	Уурхайн жилийн хүчин чадал	мян.ш/жил	10714.29	Жилд нийтдээ үйлдвэр 183 хоног ажиллана.

Тоосгоны үйлдвэрийн хоногийн хүчин чадал 58.65 мян.ш, цагийн хүчин чадал 6.9 мян.ш байхаар тооцоо гарч байна.

Тоосго үйлдвэрлэх технологи:

Тоосго үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь ерөнхийдөө: ТҮҮХИЙ ЭД, МАТЕРИАЛЫГ БУТЛАХ, ШИГШИХ ► ТҮҮХИЙ ТООСГО ҮЙЛДВЭРЛЭХ ► ХАТААХ ► ШАТААЖ БОЛОВСРУУЛАХ ► ЭЦСИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХЭРЭГЛЭГЧДЭД НИЙЛҮҮЛЭХ гэсэн технологийн дарааллаар ажиллана.



Зураг 1.2. Тоосго үйлдвэрлэлийн технологийн дамжлага схем

1.9. ҮЙЛДВЭРИЙН ҮНДСЭН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ИЖ БҮРДЭЛ

Тоосго үйлдвэрлэх үйл ажиллагаа нь түүхий эд, материалыг бутлан үйлдвэрлэлд бэлдэх, тоосго үйлдвэрлэх, хатаах, шатааж боловсруулах, эцсийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд нийлүүлэх гэсэн ерөнхий шат дараалалтай явагдана.

Хүснэгт 1.8. Тоосго үйлдвэрлэлийн үндсэн тоног төхөөрөмжүүд

№	Тоног төхөөрөмжүүд	Марк	Хүчин чадал	Тоо
1	Утгуурт ачигч	ZL30E	1.5 м³	1
2	Хайрцагт тэжээгүүр	ZYM50	10-25 м³/цаг	1
3	Алхат бутлуур	GP600x500	20-30 м³/цаг	2
4	Хос голт зуурагч	SJ2500	25-30 м³/цаг	2
5	Вакум хэвлэгч	ZYM30	6-8 мян.ш/ц	1
6	Гулдмай таслагч	Гидрийн	1-1.3 м/сек	1
7	Тоосго зүсэгч	Автомат синхрон	26 удаа/мин	1
8	Туузан дамжуулагч	DS50x8	1.3 м/сек	4



Зураг 1.3. Тоосго үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн дамжлага схем

БҮЛЭГ-2. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮД

2.1. АГААРЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

Уурхайн техник, технологийн үйл ажиллагааны нөлөөгөөр үүсэх тоос, шороо болон угаарын хорт хий агаар орчныг бохирдуулах эх үүсвэр болно.

Шавар олборлох уурхайд:

- *Хөрс хуулах, шавар олборлох үед тоос үүсэх,*
- *Тээврийн хэрэгсэл явах үед боссон автозамын тоос,*
- *Хүнд даацын машин механизм, тоног төхөөрөмжүүдийн дотоод шаталтын хөдөлгүүрийн ажиллагаанаас гарах утаа болон хорт хий,*
- *Уурхайн малталтууд болон овоолгын талбайгаас салхинд хийсэх тоос,*
- *Хөрс болон шаврыг тээвэрлэх үед үүсэх тоос, шороо нь агаар орчныг бохирдуулах эх үүсвэр болдог.*

Үүнээс уурхайн малталтууд болон овоолгын талбайгаас салхинд хийсэх тоос шороо агаар орчныг байнга бохирдуулдаг бөгөөд салхины хурд, агаарын чийгшил болон хуурайшил зэргээс шалтгаалан жилийн дөрвөн улиралд нөлөөллийн хэмжээ харилцан адилгүй байдаг.

2.2. ХӨРСНИЙ ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

Хүнд машин механизмын хөдөлгөөнөөс хөрс эвдрэх, элэгдэлд орох зэргээр хөрс, ургамлын хүний үйл ажиллагаанд өртөж буй талбайн хязгаар нь түүнээс нилээд хол зайд, наад зах нь 500-1000 м болж, нөлөөллийн хүрээ нь тэлж болохыг цаашид анхаарах шаардлагатай юм.

Шавар олборлох ажлын байгаль орчинд үзүүлэх экологийн гол үр дагавар нь газрын хурдсыг эвдэж, нүх, карьер үүсэх, улмаар агаарын тоосны бохирдол ихсэх, энэ нь ойр орчимдоо тархах, байгаль хамгаалах шаардлагатай арга хэмжээ авч сөрөг нөлөөллийг бууруулахгүй бол цөлжилт явагдах, цаашид хүрээгээ тэлэхэд хүргэж болзошгүй.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглаж буй шатах тослох материалын хадгалалт, ашиглалтанд байнгын хяналт тавьж болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байх шаардлагатай болно.

2.3. УСНЫ ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

Уурхайн орчим урсгал ус байхгүй бөгөөд геологи хайгуулын үед шаврын олборлолтын давхаргад гүний ус илрээгүй нилээд гүнд байгаа учир энэ төрлийн нөлөөлөл бага юм.

2.4. УРГАМАЛАН НӨМРӨГТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

Төсөл хэрэгжих явцад тухайн орд ашиглах газрын ургамлын бүрхэвч агаар, хөрсний бохирдлоос үүдэн ихээхэн хэмжээний доройтолд орсон нь ажиглагдаж байсан.

2.5. АМЬТНЫ АЙМАГТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

Төслийн үйл ажиллагааны улмаас амьтны аймгийн төлөөлөгчдийн идэш тэжээлийн хэлхээ холбоо тасрах, амьдрах нутгийн хүрээ хумигдах, нүүдэллэх талбай хаагдах, техникийн дуу чимээ, доргио чичиргээ, бензин тосны үнэр зэргээс тайван байдал нь алдагдаж, амьдрах орчноосоо дайжих байдлаар тухайн экосистем тодорхой хэмжээгээр өөрчлөгдөнө.

Сээр нуруугүй амьтад, ялангуяа шавж, аалз хэлбэртэн байгалийн аливаа нэг биоценозод тохиолдох нийт амьтдын биомассын ихэнх буюу 90 хүртэл хувийг бүрдүүлэх бөгөөд тухайн орчинд явагдаж байгаа бодис, энергийн эргэлт, хувирлыг хэвийн явуулах, түргэтгэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Ийм учраас хөрсний амьтдын зонхилох хэсгийн зүйл, тэдгээрийн тоо толгойн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсноор тухайн экосистемийн тогтолцоонд өөрчлөлт хувьсал гарах нь дамжиггүй.

Шатах, тослох материал хадгалах, зөөвөрлөх үед асгах, хатуу хог хаягдлыг ил задгай хаях, эвдэрсэн газрыг хөрсжүүлэх ажил орхигдоход хөрсөнд амьдрагч сээр нуруугүйтэн, жижиг мэрэгчид, тэдгээрээр хооллогч хөхтөн, шувуудын тоо толгой цөөрөх үйл явц ажиглагдана. Энэ нь амьтан, ургамлын аймгийн төлөөлөгчид харилцан шүтэлцээтэйгээр экосистемийг бүрэлдүүлэх биологийн зүй тогтол юм.

2.6. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛС

Тус тоосгоны шаврын ордын талбай нь байгалийн цогцолборт газарт хамаарахгүй бөгөөд түүх, соёлын дурсгалт зүйл талбайн хэмжээнд байхгүй. Хэрэв олборлолтын явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл дүүргийн болон нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, холбогдох мэргэжлийн байгууллагуудад хандах хэрэгтэй.

БҮЛЭГ-3. ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

3.1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг бүрэн хэрэгжүүлсэн ба холбогдох тайлбар, үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэнд харууллаа.

Хүснэгт 3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа, давтамж	Хэрэгжүүлэгч	Зардал, мян.төг	Гарсан үр дүн
Хөрсөн бүрхэвч					
1	Ажилчдад шатах, тослох материалтай хэрхэн харьцах, түүнээс үүсэх эрсдэлээс хэрхэн сэргийлж, ямар арга хэмжээ авах талаар сургалт зохион байгуулсан	Жилд 1 удаа	“Эм эл ти престиж” ХХК	150.0	Шатах тослох материалын асгаралтаас хөрс бохирдохоос сэргийлсэн
2	Тээврийн хэрэгслийг маршрутын бус замаар явахыг хориглосон таних тэмдэг бүхий самбаруудыг сайжруулсан	Төслийн үйл ажиллагааны явцад	“Эм эл ти престиж” ХХК	150.0	Хөрс элэгдэл эвдрэлд орох, тоосжилтоос сэргийлсэн
3	ШТМ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах, асгарч алдагдахаас сэргийлэх, хөрс, гүний ус бохирдохоос сэргийлэх, бохирдсон тохиолдолд саармагжуулах, аюулгүй болгох арга хэмжээ авч ажилласан.	Байнга	Байгаль орчны мэргэжилтэн	100.0	Хөрс бохирдохоос сэргийлсэн
Агаарын орчин					
1	Шаврын олборлолтын үед тоосжилт ихээр үүсэх үед усалгаа хийх, салхи ихтэй үед тоос багасгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн	Байнга	“Эм эл ти престиж” ХХК	Дотоод төлөвлөлтөөр	Тоосжилтоос сэргийлсэн
2	Тоос шороотой нөхцөлд ажиллаж байгаа ажилчдыг тоосжилтоос хамгаалах зорилгоор өдөрт нормын сүү, цагаан идээ өгсөн	Байнга	“Эм эл ти престиж” ХХК	Дотоод төлөвлөлтөөр	Ажилчдын эрүүл мэндэд анхаарсан
3	Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмолжуулах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авч ажилласан	Төслийн үйл ажиллагааны явцад	“Эм эл ти престиж” ХХК	100.0	Агаарын бохирдлоос сэргийлсэн
Усан орчин					
1	Үер усны аюулаас сэргийлэхийн тулд хамгаалалтын далан байгуулсан	Төслийн үйл ажиллагааны явцад	“Эм эл ти престиж” ХХК	Дотоод төлөвлөлтөөр	Үер усны аюулаас сэргийлсэн
-	Нийт дүн		500.0		

3.2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Шар хөвийн хоолой” тоосгоны шаврын уурхай нь 2021 онд ТЭЗҮ-ээ батлуулан 2022 оноос шинэчилсэн ТЭЗҮ-ээрээ үйл ажиллагаа явуулж эхэлж байгаа бөгөөд энэ онд уурхайн талбайд нөхөн сэргээлтийн ажил төлөвлөөгүй болно.

Гэвч уурхайн талбайн орчимд биологийн нөхөн сэргээлтийн ажил 20 ширхэг улиас мод тарьж, мод тарьсан хэсгийг хашаажуулан хамгаалах ажлыг гүйцэтгэлээ. Энэ ажилд нийтдээ 1.75 сая төгрөг зарцуулсан ба цаашдаа жил бүр нэмж мод тарьж ажиллана.



Зураг 3.1. Уурхайн талбайд мод тарьж буй байдал



Зураг 3.2. Тарьсан модоо хашаажуулж хамгаалсан байдал

3.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2023 онд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд НБОГ-с санал болгосон Сонгинохайрхан дүүргийн 21-р хорооны нутаг дэвсгэр дэх Инчон мөрөөдлийн төгөлд нэгдсэн зохион байгуулалтаар мод тарих ажилд оролцохоор төлөвлөсөн.

Хүснэгт 3.2. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөлт

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
1.	Дүйцүүлэн хамгаалалт	НБОГ-с санал болгосон газарт	Нэгдсэн зохион байгуулалтаар мод тарих ажилд оролцоно	1	1'000'000.0	1'000'000.0
-	Нийт	-	-	-	-	1'000'000.0

Энэхүү нэгдсэн зохион байгуулалтаар мод тарих ажилд 1.0 сая төгрөг шилжүүлэн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг биелүүлсэн.



Зураг 3.3. Дүйцүүлэн хамгаалах чиглэлээр мод тарьсан ажлын тайлан

3.4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

- ✓ Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ төлөвлөгдөөгүй болно.

3.5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

- ✓ Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ төлөвлөгдөөгүй ба 2023 оны ашиглалтын явцад түүх, соёлын дурсгалт зүйл илрээгүй болно.

3.6. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Ажилчдын эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын дагуу ажилчдад хамгаалах хэрэгсэл, нүдний шил, хамар амны маск, чихний бөглөө, хатуу малгай, бээлий, тохиромжтой гутал зэрэг ХАБЭА-н хэрэгслээр бүрэн хангаж, байнга өмсүүлж, хэрэглүүлж хэвшүүлсэн. Төслийн үйл ажиллагаа эхэлсэнээс хойш ямар нэгэн осол аваар гараагүй болно.



Зураг 3.4. Ажилчдын хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслүүд



Зураг 3.5. Аюулгүй ажиллагааны самбар



Зураг 3.6. Гал унтраах аюулгүй ажиллагааны хэрэгслүүд

Бид ажилчдынхаа эрүүл, аюулгүй ажиллах нөхцлийг бүрдүүлж гэнэтийн болон болзошгүй осол, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллахаар хичээж ажиллаж байгаа ба манай төслийн үйл ажиллагаа эхэлсэн үеэс эхлэн ямар нэгэн осол аваар гараагүй болно.

Хүснэгт 3.3. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Зардал, мян.төг	Хэрэгжүүлсэн хугацаа
1	Автомашин, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог зэргээс хээрийн түймэр гарч болзошгүй	Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулсан	100.0	Төслийн үйл ажиллагааны явцад
		Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад байрлуулсан	100.0	Уурхай эхлэх үед
3	Хүчтэй аадар бороо, аянга цахилгааны улмаас ажлын байрны аюулгүй байдал, цахилгаан тасрах, хүний амь нас, эрүүл мэнд хохирох	Аянга, цахилгаантай ширүүн бороотой үед үйлдвэрийн ажлыг түр зогсоож байсан	-	Төслийн хугацаанд
4	Ажилчид бэртэх, амь нас эрсдэх, шавар олборлолт болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Ажилчдыг ажилдаа гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч ажилласан	-	Өдөр бүр
		Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулсан	100.0	Жилд 1 удаа
5	Жолооч нарын санамсар болгоомжгүй үйлдлээс тээврийн хэрэгслүүд мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх зэргээр гэмтээж, бэртээх гэх мэт осол аваар гарах	-Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулсан, -Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулсан	100.0	Жил бүр
-	Нийт		400.0	

3.7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгахын тулд Сонгинохайрхан дүүргийн “Тохижилт үйлчилгээний төв” болон дүүргийн татварын хэлтэстэй 2023 оны 03-р сарын 18-ны өдөр № 758/32 тоот гэрээг байгуулан ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цуглуулж хадгалан тээвэрлүүлэх ажлыг гүйцэтгүүлж байна.

Энэхүү гэрээгээр Монгол Улсын Хог хаягдлын тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 63-р тогтоолоор батлагдсан “Хот тохижилт, цэвэрлэгээний талаар албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дагаж мөрдөх журам”, “Журамд өөрчлөлт оруулах тухай” Нийслэлийн ИТХ-ын 2012 оны 61-р тогтоол, Дүүргийн засаг даргын 2013 оны 04-р сарын 26-ны өдрийн 165-р захирамжийг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байгаа болно.

Дээрх гэрээний дагуу 185'000.0 төгрөгийг Сонгинохайрхан дүүргийн “Тээвэрлэлт үйлчилгээний төв”-д төлсөн болно.

2023 оны 1-р сард зохион байгуулсан шинэ хогийн цэгийг цэвэрлэх ажилд оролцож нөлөөллийн бүсийнхээ орчмыг хогийг цэвэрлэв.



Хуулдас - 20

БАТЛАВ
“ЭМ ЭЛ ТИ ПРЕСТИЖ” ХХК-НИЙ
ТАХИЛАГЧ / Х.ТЭМҮҮЛЭН /

БАТЛАВ
“МАРГАД ЭРДЭНЭ УУЛ” ХХК-НИЙ
ТАХИЛАГЧ / Х.МАРГАД /

**ХЭРЭГЛЭЭНЭЭС ГАРСАН ШИНГЭН ХОГ ХАЯГДАЛ ЗӨӨВӨРЛӨХ,
ШУГАМЫН БӨГЛӨРӨЛ ГАРГАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

2022 он 03 сар 24 өдөр /Дугаар: АР / 22 / 17/ Улаанбаатар хот

Нэг талын “ЭМ ЭЛ ТИ ПРЕСТИЖ” ХХК (шинэглэл “Зочин” г.т) РД: 5121442, түүнийг төлөөлж /Х.ТЭМҮҮЛЭН/ албан тушаалай /Х.ТЭМҮҮЛЭН/ талын “МАРГАД ЭРДЭНЭ УУЛ” ХХК (шинэглэл “Түвшин” г.т) РД: 6342015, түүнийг төлөөлж менежер Ж.Марал нар доорх нөхцөлөөр харилцаж төлөрлөж байгуулав.

Нэг. НИЙТЛЭГ ТААЛТ

- Гүйцэтгэх тал захиалагчийн хүсэлтээр болж үс төмөрлөх үйлчилгээг чамартай, түргэн шуурхай хийж гүйцэтгэнэ.
- Дүрх ажил нь байдал хамгаалах хууль, арга-агариар тухай хууль, бусад холбогдох дүрм зэмлэг бүрэн мөрдөгч байна.
- Хоёр тал харилцаж төлөрлөхөөр үйлчилгээний ажлын гүйцэтгэх дээр үүнтэй байна. Уг дүрх НОАТ болон Болор үс цэвэрлүүлсний төлбөр багтсан болно. Үүнд:
10тн – 120,000т / Нэг түүх хэрэг мөнгө төгрөг /
Буудлага – 200,000т / Хоёр түүх мөнгө төгрөг /
/буудлага - Худал хоорондын бичиглэлийг усаар буудаж гаргах, болорын дэгийг өндөр даралттай усаар халдснор оруулах/
- Ажил гүйцэтгэх хугацааг хоёр тал харилцаж төлөрлөхөөр тогтоох бөгөөд мөхүү гэрээ нь 2022 оны 03 сарын 24-ний өдөрөөс 2023 оны 03 сарын 24-ний өдөр хүртэл хүчинтэй байна.
- Гэрээний хүчинтэй хугацаа дуусахад болон ч аль нэг тал ариулах тухай бичгээр мэдэгдэхгүй тохиолдолд гэрээ 1 жилээр сунгагсад тооцно.

Хоёр. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- Үйлчилгээний дуудлагыг тухайн болж үс төмөрлөх хийгнэ аргийн ажил өдөр гүйцэтгэнэ өгсөн байна. /Дуудлагын утас: 9626-7373/
- Болор үс сорох явдал хамгаат тавьж, дутуу сорох тохиолдолд тухай бүрт нь гүйцэтгэнэ мэдэгдэж, шаардлага тавьж, доголлыг тогтоон өөрийнх нь зардалар дахин оруулна.
- Гүйцэтгэнэ талтай төлөрлөхөөр дагуу аливаа урамшуулал, хяналтынтайг ижилт аливаа хамгаат дагуу хэрхэн.
- Зайншгүй шаардлагатай нөхцөл ажил /хугацаа бичгээр гаргах, тайлах, худал цэвэрлэх гэх мэт/ гарвал үйлчилгээ гүйцэтгэнэ харилцаж төлөрлөхөөр дагуу үйлчилгээ хийгнэ.
- Төлбөрийг бэлэн болон дансаар төлөрлөхөөр дагуу талын.
- Ажлын хэргийг дараа сарын хувсгийн эхний 5 /тан/ өдөр хэснэжсэн бөгөөд хэснэжсэн хоёр захиалагч тал хувсгийн 5 /тан/ өдөр багтаан гүйцэтгэнэ. Нөхснөжсөн дүг “МАРГАД ЭРДЭНЭ УУЛ” ХХК-ийн 5009952783 /Хан баян/ тэгт дансанд шилжүүлнэ.

Дав. ГЭРЭЭНД НЭМЭЛТ ООРЧЛОЛТ ОРУУЛАХ

7.1. Ажил гүйцэтгэх явдал гэрээнд оруулсан аливаа нөхцөл, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг түрэмж хүчин төгөлдөр болно. Нөхцөл өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД:

“ЭМ ЭЛ ТИ ПРЕСТИЖ” ХХК Хаяг: Улаанбаатар хот, СХДүүрэг, 32-р хороо, Энхэл Утас: 9901-1583, 9011-6534 И-Мэйл: em.el.ti.prestizh@gmail.com Менежер: <i>Х.ТЭМҮҮЛЭН</i> Утас: <i>99011583</i> И-Мэйл: <i>em.el.ti.prestizh@gmail.com</i> Нэгтгэн бодогч: Утас: _____ И-Мэйл: _____	“МАРГАД ЭРДЭНЭ УУЛ” ХХК Хаяг: Улаанбаатар хот, БГДүүрэг, 3-р хороо, Энхэлдэгийн гудамж Утас: 9626-7373, 8801-4340 И-Мэйл: margad.erdene.uul@gmail.com Менежер: <i>Ж.Марал</i> Утас: 9626-7373 И-Мэйл: margad.erdene.uul@gmail.com Нэгтгэн бодогч: <i>Ж.Марал</i> Утас: 9912-1354 И-Мэйл: margad.erdene.uul.office@gmail.com
--	--

Зураг 3.9. Бохир ус татан зайлуулах гэрээ

Мөн “Маргад эрдэнэ уул” ХХК-тай “Хэрэглээнээс гарсан шингэн хог хаягдал зөөвөрлөх, шугамын бөглөрөл гаргах ажил гүйцэтгэх гэрээ”-г 2022 оны 3-р сарын 24-ний өдөр байгуулж ажиллаж байна. Энэ гэрээний дагуу гүйцэтгэсэн ажилд нийтдээ 120 мянган төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 3.4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хэрэгжүүлэгч	Зардал, мян.төг
1	Төвлөрсөн цэгт хогийг тухай бүрт тээвэрлүүлэх ажлыг гэрээт байгууллагаар гүйцэтгүүлэв	“Эм эл ти престиж” ХХК	185.0
2	Бохир ус татан зайлуулах ажлыг гэрээт байгууллагаар гүйцэтгүүлэв		120.0
3	Өмнөх жилүүдэд үүссэн хур хогноос хэсэгчлэн цэвэрлэж зайлуулах ажлыг гүйцэтгэж байна.		100.0
4	Дахин ашиглах, боловсруулах боломжтой хог хаягдлыг хоёрдогч түүхий эдийн цэгт тушаах, ангилсан хаягдлыг агуулах нэмэлт хогийн савнууд суурилуулж, тэмдэгжүүлэх ажил гүйцэтгэсэн		100.0
-	Нийт дүн	505.0	

3.8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хөрс, усны шинжилгээ, агаар, дуу чимээний хэмжилтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэлээ. Энэ ажилд нийтдээ 400.0 мянган төгрөг зарцуулсан болно.



“НАРТ ШУУН КОНСАЛТИНГ” ХХК
ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан
 дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10
 Утас: (976)-99176123, 99231836
 E-mail: nartconsulting@gmail.com



№ 23/10-20/1

Захиалагч: “Эм Эл Ти Престиж” ХХК
 Дээж авсан цэг: СХД 32-р хороо, Эмээлт тоосгоны үйлдвэр
 Сорьц авсан огноо: 2023 оны 10 сар 16 өдөр
 Шинжилгээ хийсэн огноо: 10 сарын 20
 Хариуцах утас:

1. ХӨРСНИЙ ХИМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Дээж авсан гүн, см	pH	Давс, %	ЦДЧ, ds/m	Ялзмаг, %	CaCO ₃ , %	NO ₃ , мг/100г	Солилцох сууриуд, мг-экв/100 г		Шим тэжээлийн элементүүд, мг/100г	
								Ca ²⁺	Mg ²⁺	P ₂ O ₅	K ₂ O
Дээж 1											
1	0-20	8.59	0.070	0.164	0.97	2.24	0.51	10	15	2.9	16

2. ХӨРСНИЙ МЕХАНИК БҮРЭЛДЭХҮҮН

№	Дээж авсан гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Дээж 1								
1	0-20	25.4	36.0	14.3	9.2	3.6	11.6	24.3

3. ХӨРСНИЙ ЭРҮҮЛ АХУЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН. IГР ХӨРСӨНД

№	Дээжний дугаар	Нянгийн тоо	Гэдэсний савханцрын титр (E.coli) MNS 3297:2019			Анаэробын (Cl.perfringens) MNS 3297:2019	
			Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг
1	Дээж 1	3.9*10 ⁵	0.1<	1	0.1<	1	

4. ХӨРСНИЙ ХҮНД МЕТАЛЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дээж авсан газар, Газар зүйн байршил	Дээж авсан гүн, см	Cr	Pb	Cd	Zn	Cu	Ni
		мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг
Дээж 1	0-20	40.5	40.0	0.0	51.0	25.0	15.5
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019							
Элсэрхэг хөрс		60	50	1	100	60	60
Шавранцар хөрс		100	70	1.5	150	80	100
Шаварлаг хөрс		150	100	3	300	100	150

**Харгалзах түвшин * Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарна*

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТУУД: (Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд MNS3310:1991, MNS ISO10390, хөрсний механик бүрэлдэхүүн MNS6824:2020, Эрүүл Ахуйн Шинжилгээний Стандарт MNS 5367:2004, MNS6341:2012, Хүнд металлуудыг -хаан дарсанд атом шингээлтийн спектрометрээр MNS ISO 11466:2007)

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭСЭН:
 ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ



Х.УУГАНЦЭЦЭГ, Д.ЭНХЧИМЭГ
 Г.СОЛОНГО Ph.D, Дэд профессор

2023 ОНЫ 10 САРЫН 20

Зураг 3.10. Хөрсний шинжилгээний хариу-1



“НАРТ ШУУН КОНСАЛТИНГ” ХХК ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан
дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10
Утас: (976)-99176123, 99231836
E-mail: nartconsulting@gmail.com

№ 23/10-20/2

Захиалагч: “Эм Эл Ти Престиж” ХХК

Дээж авсан цэг: СХД 32-р хороо, Эмээлт тоосгоны үйлдвэр

Сорьц авсан огноо: 2023 оны 10 сар 16 өдөр

Шинжилгээ хийсэн огноо: 10 сарын 20

Харилцах утас:

1. ХӨРСНИЙ ХИМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Дээж авсан гүн, см	pH	Давс, %	ЦДЧ, ds/m	Ялзмаг, %	CaCO ₃ , %	NO ₃ , мг/100г	Солилцох сууриуд, мг- экв/100 г		Шим тэжээлийн элементүүд, мг/100г	
								Ca ⁺²	Mg ⁺²	P ₂ O ₅	K ₂ O
Дээж 2											
1	0-20	7.52	0.026	0.061	2.61	0.0	0.37	24	5	2.0	34

2. ХӨРСНИЙ МЕХАНИК БҮРЭЛДЭХҮҮН

2. ХӨРСНИЙ МЕХАНИК БҮГДЭДХ ГҮН								
№	Дээж авсан гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Дээж 2								
1	0-20	12.3	40.6	24.7	9.2	4.5	8.6	22.4

3. ХӨРСНИЙ ЭРҮҮЛ АХУЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН. IГР ХӨРСӨНД

№	Дээжний дугаар	Нянгийн тоо	Гэдэсний савханцрын титр (E.coli) MNS 3297:2019			Анаэробын (C.l.perfringens) MNS 3297:2019	
		Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг		Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг
1	Дээж 2	4.0*10 ⁵	0.1<	1		0.1<	1

4. ХӨРСНИЙ ХҮНД МЕТАЛЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дээж авсан газар, Газар зүйн байршил	Дээж авсан гүн, см	Cr	Pb	Cd	Zn	Cu	Ni
		мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг
Дээж 2	0-20	39.4	39.3	0.0	60.6	23.2	13.0
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019							
Элсэрхэг хөрс		60	50	1	100	60	60
Шавранцар хөрс		100	70	1.5	150	80	100
Шаварлаг хөрс		150	100	3	300	100	150

*Харгалзах түвшин * Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжэнд хамаарна

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТУУД: (Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд MNS3310:1991, MNS ISO10390, хөрсний механик бүрэлдэхүүн MNS6824:2020, Эрүүл Ахуйн Шинжилгээний Стандарт MNS 5367:2004, MNS6341:2012, Хүнд металлуудыг -хаан дарсанд атом шингээлтийн спектрометрээр MNS ISO 11466:2007)

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭСЭН: Х.УУДАНЦЭЦЭГ, Д.ЭНХЧИМЭГ
ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: Г.СОЛОНГО Ph.D, Дэд профессор

2023 ОНЫ 10 САРЫН 20 2

Зураг 3.11. Хөрсний шинжилгээний хариу-2



“НАРТ ШУҮН КОНСАЛТИНГ” ХХК ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан
дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10
Утас: (976)-99176123, 99231836
E-mail: nartconsulting@gmail.com

№ 23/06-12/1

Захиалагч: “Эм Эл Ти престиж” ХХК
Дээж авсан цэг: СХД 32 хороо Эмээлт тоосгоны үйлдвэр
Сорьц авсан огноо: 2023 оны 06 сар 08 өдөр
Уст цэгийн төрөл: гүний худаг
Зориулалт:
Харилцах утас:
Аргын стандарт: MNS1097:1970

Катион	1 дм ³			Анион	1 дм ³		
	мг/л	мг-экв/л	мг-экв/%		мг/л	мг-экв/л	мг-экв/%
Ca ⁺⁺	65.00	3.24	45.60	CO ₃ ⁻	0.00	0.00	0.00
Mg ⁺⁺	39.00	3.21	45.11	HCO ₃ ⁻	281.00	4.61	64.73
Fe	0.00	0.00	0.00	Cl ⁻	61.00	1.72	24.19
K ⁺	2.00	0.05	0.72	SO ₄ ⁻	27.00	0.56	7.91
Na ⁺	14.00	0.61	8.56	NO ₃ ⁻	14.00	0.23	3.17
Дүн	120.00	7.11	100.00	Дүн	383.00	7.11	100.00

Анион катионуудын нийлбэр:
(Σ_{A+K} 503 мг/л
HCO₃-ийн хагасыг хассан анион,
катионуудын нийлбэр: 362.5 мг/л
Физик үзүүлэлтүүд
Өнгө: 0-өнгөгүй,
Үнэр: 0-үнэргүй
Булингар: Булингаргүй
Тунгалаг: Тунгалаг

Хуурай үлдэгдэл, мг/л: 245 ppm
Ерөнхий хатуулаг: 6.43 мг-экв/л
/ хатуу ус/
Урвалын орчин: pH- 7.74
Цахилгаан дамжуулах чадвар:
EC -0.603 ds/m
TDS: 0.329 ppm

$$M(0.5) = \frac{HCO_3 \ 65 \ [Cl \ 24 \ SO_4 \ 8]}{Ca \ 46 \ Mg \ 45 \ [Na \ 9]}$$

Химийн бүрэлдэхүүнээрээ Гидрокарбонатын анги, кальцийн бүлэг, II төрлийн цэнгэгдүү буюу харьцангуй ихэвтэр эрдэсжилттэй, хатуу ус.

Жич: усны сорьцыг шинжлүүлсэн байгууллага хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно.

ЗАДЛАН ШИНЖЛЭГЧ: Д.ЭНХЧИМЭГ
ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: С.СОНГО Ph.D, Дэд проф.





“НАРТ ШУУН КОНСАЛТИНГ” ХХК ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан
дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10
Утас: (976)-99176123, 99231836
E-mail: nartconsulting@gmail.com

№ 23/10-24

Захиалагч: “Эм Эл Ти престиж” ХХК
Дээж авсан цэг: СХД 32 хороо Эмээлт тоосгоны үйлдвэр
Сорьц авсан огноо: 2023 оны 10 сар 16 өдөр
Уст цэгийн төрөл: гүний худаг
Зориулалт:
Харилцах утас:
Аргын стандарт: MNS1097:1970

Катион	1 дм ³			Анион	1 дм ³		
	мг/л	мг-экв/л	мг-экв/%		мг/л	мг-экв/л	мг-экв/%
Ca ⁺⁺	65.00	3.24	45.60	CO ₃ ⁻	0.00	0.00	0.00
Mg ⁺⁺	39.00	3.21	45.11	HCO ₃ ⁻	281.00	4.61	64.73
Fe	0.00	0.00	0.00	Cl ⁻	61.00	1.72	24.19
K ⁺	2.00	0.05	0.72	SO ₄ ⁻	27.00	0.56	7.91
Na ⁺	14.00	0.61	8.56	NO ₃ ⁻	14.00	0.23	3.17
Дүн	120.00	7.11	100.00	Дүн	383.00	7.11	100.00

Анион катионуудын нийлбэр:
(Σ_{A+K} 503 мг/л
НСО₃-ийн хагасыг хассан анион,
катионуудын нийлбэр: 362.5 мг/л
Физик үзүүлэлтүүд
Өнгө: 0-өнгөгүй,
Үнэр: 0-үнэргүй
Булингар: Булингаргүй
Тунгалаг: Тунгалаг

Хуурай үлдэгдэл, мг/л: 246 ppm
Ерөнхий хатуулаг: 6.45 мг-экв/л
/ хатуу ус/
Урвалын орчин: рН- 7.75
Цахилгаан дамжуулах чадвар:
ЕС -0.601 ds/m
TDS: 0.334 ppm

$$M(0.5) = \frac{HCO_3 \ 65 \ [Cl \ 24 \ SO_4 \ 8]}{Ca \ 46 \ Mg \ 45 \ [Na \ 9]}$$

Химийн бүрэлдэхүүнээрээ Гидрокарбонатын анги, кальцийн бүлэг, II төрлийн цэнгэгдүү буюу харьцангуй ихэвтэр эрдэсжилттэй, хатуу ус.

Жич: усны сорцыг шинжлүүлсэн байгууллага хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно.

ЗАДЛАН ШИНЖЛЭГЧ: Д.ЭНХЧИМЭГ
ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: Г.СОЛОНГО Ph.D, Дэд проф.

3.9. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Манай компани Сонгинохайрхан дүүрэг болон 32-р хороотойгоо нягт уялдаа холбоотой ажилладаг бөгөөд дүүргийн 30 жилийн ойг тохиолдуулан хамтын ажиллагааны талархал бичиг хүртэв.



Зураг 3.14. Дүүрэг, хорооноосоо хамтын ажиллагааны талархал хүртэв

3.10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тухайн жилийн буюу 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөг бүрэн биелүүлж ажилласан ба холбогдох тайлбар, үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэнд харууллаа.

Хүснэгт 3.5. Удирдлага зохион байгуулалтын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

№	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа, давтамж	Хэрэгжүүлэгч	Зардал, мян.төг
1	Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулж, зөвлөгөө авч ажилласан	2023 онд	“Эм эл ти престиж” ХХК	500.0
2	Шаврын орд, үйлдвэрийн ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрмийн талаар сургалт, семинарыг тогтмол зохион байгуулсан	Жил бүр	“Эм эл ти престиж” ХХК	Дотоод төлөвлөлтөөр
3	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр бүрэн хангаж ажиллуулсан	Төслийн үйл ажиллагааны явцад	“Эм эл ти престиж” ХХК	Дотоод төлөвлөлтөөр
4	Ажилчдыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулсан	Жилд 1 удаа	“Эм эл ти престиж” ХХК	Дотоод төлөвлөлтөөр
5	Гал унтраах хэрэгслээр үйлдвэрийн гадаад орчныг бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар арга хэмжээ зохион байгуулсан	Жил бүр	“Эм эл ти престиж” ХХК	Дотоод төлөвлөлтөөр
6	Байгаль орчны аудит хийлгэсэн	2 жил тутамд	“Эм эл ти престиж” ХХК	Дотоод төлөвлөлтөөр
7	Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байсан	Төслийн хугацаанд	“Эм эл ти престиж” ХХК	Дотоод төлөвлөлтөөр
-	Нийт дүн			500.0

“Эм эл ти престиж” ХХК нь Сонгинохайрхан дүүргийн 40 гаруй иргэдийг ажлын байраар ханган үйл ажиллагаагаа явуулж байна.

Бид цаашдын үйл ажиллагааныхаа явцад ажиллах хүчнийхээ эрүүл, аюулгүй ажиллах нөхцлийг бүрдүүлж байгаль орчинд ээлтэй, сөрөг нөлөөлөл багатайгаар үйл ажиллагаагаа явуулах бүх шатны арга хэмжээгээ сайжруулан ажиллах болно.

3.11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

"Эм эл ти престиж" ХХК нь жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага, нутгийн иргэдэд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүргүүлж ажилладаг.

БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөө болон биелэлтийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 3.6. Олон нийтэд төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах хуваарь

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд		Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Зохион байгуулах газар
Нийслэлийн байгаль орчны газар, БОАЖЯ	Хорооны ИНХ	Хуралд танилцуулах	БОМТ-ийн 2023 оны хэрэгжилтийн тайлан	11-р сарын 01-ний өдрийн дотор	Хорооны төв
	Дүүргийн ЗД, БОХХБайцаагч	Уулзалт			Дүүргийн төв
Төрийн захиргааны төв байгууллага	БОАЖЯ-ны ХБОБНУГ-т	Тайлан, төлөвлөгөөг тайлан хэлбэрээр болон Файл хэлбэрээр	2023 оны БОМТ	12-р сарын 01-ний өдрийн дотор	УБ хот

Бид байгаль орчны менежментийн төлөвлөгөө, уг төлөвлөгөөний биелэлт болон олон нийтэд тайлагнах, байгаль орчны чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдээ мэдээллэх, сурталчлах ажлуудаа цаашид илүү сайжруулан ажиллахаар хичээж байна.

3.12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН НЭГТГЭЛ

2023 онд БОМТ-нд нийт 4'450.0 мян.төг зарцуулахаар төлөвлөсөн ба биелэлтийн гүйцэтгэлээр 5'055.0 мян.төгрөг зарцуулсан буюу 113.5%-ийн гүйцэтгэлтэй ажилласан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 3.7. 2023 оны БОМТ-ний нийт зардал, биелэлтийн үзүүлэлтүүдийн харьцуулалт

№	Арга хэмжээ	Төлөвлөгөөнд тусгагдсан зардал, мян.төг	Биелэлтээр гүйцэтгэсэн ажлын зардал, мян.төг	Гүйцэтгэл, %
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	500.0	500.0	100%
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	2'000.0	1'750.0	87.5%
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	1'000.0	1'000.0	100%
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	Хамааралгүй	-	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Хамааралгүй	-	-
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	300.0	400.0	+100%
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	300.0	505.0	+100%
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	350.0	400.0	+100%
9	Аймаг, нийслэлийн Засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ	Төлөвлөгдөөгүй	-	-
10	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	Зардал төлөвлөгдөөгүй	500.0	100%
11	Олон нийтэд тайлагнах төлөвлөгөө	Зардал төлөвлөгдөөгүй	Тайлагнасан	100%
-	Нийт дүн	4'450.0	5'055.0	+100%

ДҮГНЭЛТ

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт орших “Эм эл ти престиж” ХХК-ний “Шар хөвийн хоолой” тоосгоны шаврын уурхайн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг БОАЖ-ын сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

Шавар олборлолт, тоосго үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах явцад нөлөөлөлд голчлон өртөгч нь хөрс, ургамал, агаар, газрын ба геологийн тогтоц юм.

Иймд сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх зэрэг ажлуудыг тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу хэрэгжүүлж, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт заагдсан арга хэмжээг цаг тухайд нь гүйцэтгэж, үр дүнд нь дүгнэлт хийн ажиллалаа.

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийтдээ 4'450'000 (Дөрвөн сая дөрвөн зуун тавин мянган) төгрөг зарцуулахаар төлөвлөгдсөн.

“Эм эл ти престиж” ХХК нь 2012 онд нэмэлт өөрчлөлт орсон Байгаль орчныг хамгаалах тухай Монгол улсын хуулийн 31-р зүйлд заасны дагуу БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх үүрэгтэй. 2023 оны БОМТ-г хэрэгжүүлэхэд нийт зардлын 50% буюу 2'225'000 (Хоёр сая хоёр зуун хорин таван мянган) төгрөгийг тусгай дансанд байршуулсан.

2023 онд БОМТ-ний биелэлтийн гүйцэтгэлд нийт 5'055.0 мян.төгрөг зарцуулсан нь төлөвлөгөөнд тусгасан зардлын үзүүлэлттэй харьцуулахад 113.5%-ийн гүйцэтгэлтэй ажилласан үзүүлэлттэй байна.

Бид цаашдын үйл ажиллагааныхаа явцад байгаль орчны менежментийн төлөвлөгөө, уг төлөвлөгөөний биелэлтийн ажлуудыг холбогдох хууль, журам, стандарт, аргачлалуудад нийцүүлэн тогтмол сайжруулж ажиллах болно.